

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/145/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Улаанбаатар хот	тэргүүлэх аудитор: М. Батсуурь
2023 он	Утас: 70453317 Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn
	Аудитын менежер: М. Бат-Амгалан
	Утас: 70453799 Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
	Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Ариун төгс оршихуй Аудит
	ХХК-ийн аудитор: В. Сэлэнгэ
	Утас: 9902-3656 Цахим хаяг: ariuntugsorshihuaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ТЭС СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
М.ЛХАГВАЖАВ ТАНАА

2023.07.24 № УВА-2023/145/НА -СТА -ТЦЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200000142

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>174,349,101.86</u></b>	<b><u>190,405,625.72</u></b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,239,653.29	94,929,223.12
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,239,653.29	94,929,223.12
3121	Төгрөг	7,239,653.29	94,929,223.12
31211	Төрийн сангийн харилцах	7,239,653.29	94,929,223.12
33	АВЛАГА	91,929,063.67	1,882,165.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	463,263.67	1,882,165.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	91,465,800.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75,180,384.90	93,594,237.60
351	Түүхий эд материал	43,826,797.87	62,463,136.07
35130	Эм боох материал	43,826,797.87	62,463,136.07
354	Хангамжийн материал	31,353,587.03	31,131,101.53
35410	Бичиг хэргийн материал	1,101,700.00	680,500.00
35420	Аж ахуйн материал	15,853,876.53	16,752,503.53
35430	Сэлбэг хэрэгсэл	120,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	4,143,440.00	1,205,500.00
35460	Хүнсний материал	7,381,270.50	9,199,298.00
35470	Бусад хангамжийн материал	2,753,300.00	3,293,300.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,733,354,307.90</u></b>	<b><u>1,687,115,270.45</u></b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,733,354,307.90	1,687,115,270.45
392	Биет хөрөнгө	1,713,400,307.90	1,667,161,270.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,604,700,651.85	1,608,595,651.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	-126,837,785.94	-186,709,017.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,272,598.00	125,272,143.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-76,759,264.78	-71,648,809.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	330,667,352.56	333,240,690.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-169,203,992.17	-163,257,636.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,852,259.40	60,666,670.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,291,511.02	-38,998,421.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,434,940.00	5,434,940.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,434,940.00	-5,434,940.00
393	Биет бус хөрөнгө	19,954,000.00	19,954,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,394,000.00	20,394,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,907,703,409.76</u></b>	<b><u>1,877,520,896.17</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>6,299,377.00</u></b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	6,299,377.00
413	Өглөг	00.00	6,299,377.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	5,041,393.00
4136	Бусад өглөг	00.00	1,257,984.00

41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	1,257,984.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,907,703,409.76</b>	<b>1,871,221,519.17</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,907,703,409.76</b>	<b>1,871,221,519.17</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	312,334,144.45	312,334,144.45
51101	Өмч: - төрийн	312,334,144.45	312,334,144.45
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>808,494,521.99</b>	<b>825,904,631.40</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	808,494,521.99	862,386,521.99
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-36,481,890.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	786,874,743.32	732,982,743.32
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,907,703,409.76</b>	<b>1,877,520,896.17</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,034,536,486.96</b>	<b>1,087,836,769.39</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>630,057,426.96</b>	<b>90,226,569.39</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>108,973,126.96</b>	<b>90,226,569.39</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	108,973,126.96	86,018,369.39
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	11,392,395.49
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	108,973,126.96	74,625,973.90
120009	Бусад орлого	00.00	4,208,200.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>521,084,300.00</b>	<b>00.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	521,084,300.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>404,479,060.00</b>	<b>997,610,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>65,798,800.00</b>	<b>00.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,798,800.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>55,951,700.00</b>	<b>50,550,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,951,700.00	50,550,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>282,728,560.00</b>	<b>947,060,000.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	282,728,560.00	947,060,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>877,749,303.87</b>	<b>1,124,318,659.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>877,749,303.87</b>	<b>1,124,318,659.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>810,308,419.87</b>	<b>1,068,991,118.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>417,253,767.88</b>	<b>564,156,154.70</b>
210101	Үндсэн цалин	297,321,673.11	442,640,326.70
210102	Нэмэгдэл	69,095,762.77	88,269,628.00

210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,787,213.00	7,451,881.00
210104	Урамшуулал	32,665,819.00	24,532,173.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,383,300.00	1,262,146.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>75,432,383.16</b>	<b>70,008,014.34</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,922,587.78	55,801,854.86
210202	Тэтгэмжийн даатгал	6,127,498.82	3,731,081.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,783,694.68	2,907,585.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,343,703.16	687,953.72
210205	Эрүүл мэндийн даатгал	12,254,898.72	6,879,538.71
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>51,053,316.00</b>	<b>49,221,311.49</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,743,680.00	7,803,368.49
210302	Түлш, халаалт	40,133,984.00	41,417,943.00
210303	Цэвэр, бохир ус	4,175,652.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>57,180,540.00</b>	<b>100,145,885.00</b>
210401	Бичиг хэрэг	2,748,600.00	4,558,600.00
210402	Тээвэр, шатахуун	43,429,040.00	78,843,285.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,560,000.00	2,575,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	2,374,500.00	2,896,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,068,400.00	11,272,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>122,573,259.00</b>	<b>165,677,140.90</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,992,684.00	141,059,168.40
210502	Хоол, хүнс	15,580,575.00	17,616,972.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	7,001,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,112,000.00</b>	<b>16,722,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	50,000.00
210604	Урсгал засвар	2,112,000.00	16,672,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>892,000.00</b>	<b>2,510,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	892,000.00	2,510,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,112,250.00</b>	<b>4,144,594.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	238,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	199,034.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	2,090,000.00
210807	Газрын төлбөр	90,000.00	1,617,060.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>82,698,903.83</b>	<b>96,405,517.75</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,512,900.00	4,734,140.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,186,003.83	91,671,377.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>67,440,884.00</b>	<b>55,327,541.80</b>

2132	Бусад урсгал шилжүүлэг	64,800,000.00	48,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	64,800,000.00	48,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	87,888.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	87,888.51
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,640,884.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,640,884.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	7,239,653.29
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	7,239,653.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>156,787,183.09</u>	<u>-36,481,890.59</u>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>834,097,560.00</b>	<b>1,104,676,595.49</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>521,084,300.00</b>	<b>15,600,595.49</b>
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	15,600,595.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	11,392,395.49
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	11,392,395.49
120009	Бусад орлого	00.00	4,208,200.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	521,084,300.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	521,084,300.00	00.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>313,013,260.00</b>	<b>1,089,076,000.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,798,800.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,798,800.00	00.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>55,951,700.00</b>	<b>50,550,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,951,700.00	50,550,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	191,262,760.00	1,038,525,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	191,262,760.00	1,038,525,800.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>826,857,906.71</b>	<b>1,006,897,325.66</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>826,857,906.71</b>	<b>1,006,897,325.66</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>759,417,022.71</b>	<b>951,569,783.86</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>437,484,897.59</b>	<b>560,533,663.03</b>
210101	Үндсэн цалин	324,799,212.71	439,017,835.03
210102	Нэмэгдэл	84,000,582.88	88,269,628.00

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,948,923.00	7,451,881.00
210104	Урамшуулал	17,920,829.00	24,532,173.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,815,350.00	1,262,146.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	56,197,078.12	70,008,014.34
210201	Тэтгэврийн даатгал	40,717,280.83	55,801,854.86
210202	Тэтгэмжийн даатгал	3,869,999.31	3,731,081.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,095,899.26	2,907,585.31
210204	Ажилгүйдлийн даатгал	773,999.06	687,953.72
210205	Эрүүл мэндийн даатгал	7,739,899.66	6,879,538.71
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	50,810,816.00	48,053,311.49
210301	Гэрэл, цахилгаан	6,393,680.00	7,803,368.49
210302	Түлш, халаалт	42,603,984.00	38,400,887.00
210303	Цэвэр, бохир ус	1,813,152.00	1,849,056.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	52,151,560.00	97,704,245.00
210401	Бичиг хэрэг	2,349,500.00	4,123,400.00
210402	Тээвэр, шатахуун	36,998,060.00	76,756,845.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,560,000.00	2,575,000.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,997,500.00	5,184,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,196,500.00	9,065,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	140,673,121.00	145,155,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	115,906,621.00	119,670,500.00
210502	Хоол, хүнс	20,274,500.00	19,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,492,000.00	5,985,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,349,600.00	19,627,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,349,600.00	2,335,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	17,292,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	892,000.00	2,510,000.00
210702	Дотоод албан томилолт	892,000.00	2,510,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,112,250.00	2,886,610.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	238,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,000.00	166,034.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	1,802,000.00
210807	Газрын төлбөр	90,000.00	359,076.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,745,700.00	5,090,940.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,745,700.00	5,090,940.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,440,884.00	55,327,541.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,800,000.00	48,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	64,800,000.00	48,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	87,888.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	87,888.51
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,640,884.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,640,884.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	7,239,653.29
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	7,239,653.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,239,653.29</u>	<u>97,779,269.83</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	10,089,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	10,089,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	10,089,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	10,089,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	<u>-10,089,700.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,239,653.29	87,689,569.83
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	7,239,653.29
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,239,653.29	94,929,223.12

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	312,334,144.45	786,874,743.32	808,494,521.99	1,907,703,409.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	53,892,000.00	53,892,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,334,144.45	786,874,743.32	862,386,521.99	1,961,595,409.76
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-53,892,000.00	00.00	-53,892,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-36,481,890.59	-36,481,890.59
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,334,144.45	732,982,743.32	825,904,631.40	1,871,221,519.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	998,814,100.00	1,009,659,483.86	-10,845,383.86	101.09%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	998,814,100.00	1,009,659,483.86	-10,845,383.86	101.09%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	950,814,100.00	961,659,483.86	-10,845,383.86	101.14%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	619,347,800.00	560,533,663.03	58,814,136.97	90.50%
210101	Үндсэн цалин	576,502,200.00	439,017,835.03	137,484,364.97	76.15%
210102	Нэмэгдэл	0	88,269,628.00	-88,269,628.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,000,400.00	7,451,881.00	548,519.00	93.14%
210104	Урамшуулал	33,450,800.00	24,532,173.00	8,918,627.00	73.34%
210105	Гэрээт ажлын хөлс	1,394,400.00	1,262,146.00	132,254.00	90.52%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,418,600.00	70,008,014.34	7,410,585.66	90.43%
210201	Тэтгэврийн даатгал	52,644,600.00	55,801,854.86	-3,157,254.86	106.00%
210202	Тэтгэмжийн даатгал	6,193,500.00	3,731,081.74	2,462,418.26	60.24%
210203	ҮОМШӨ- ний даатгал	4,954,800.00	2,907,585.31	2,047,214.69	58.68%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,238,700.00	687,953.72	550,746.28	55.54%
210205	Эрүүл мэндийн даатгал	12,387,000.00	6,879,538.71	5,507,461.29	55.54%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0	48,053,311.49	-48,053,311.49	
210301	Гэрэл, цахилгаан	0	7,803,368.49	-7,803,368.49	
210302	Түлш, халаалт	0	38,400,887.00	-38,400,887.00	
210303	Цэвэр, бохир ус	0	1,849,056.00	-1,849,056.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	92,802,300.00	98,304,245.00	-5,501,945.00	105.93%
210401	Бичиг хэрэг	7,283,000.00	4,123,400.00	3,159,600.00	56.62%

210402	Тээвэр, шатахуун	76,765,600.00	76,756,845.00	8,755.00	99.99%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,382,900.00	2,575,000.00	-192,100.00	108.06%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,170,800.00	5,784,000.00	386,800.00	93.73%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	9,065,000.00	-8,865,000.00	4532.50%
2105	Нормативт зардал	125,941,800.00	145,155,500.00	-19,213,700.00	115.26%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	105,426,800.00	119,670,500.00	-14,243,700.00	113.51%
210502	Хоол, хүнс	14,515,000.00	19,500,000.00	-4,985,000.00	134.34%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000,000.00	5,985,000.00	15,000.00	99.75%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,500,000.00	29,117,200.00	-3,617,200.00	114.19%
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00	11,824,700.00	-3,824,700.00	147.81%
210604	Урсгал засвар	17,500,000.00	17,292,500.00	207,500.00	98.81%
2107	Томилолт, зочны зардал	2,350,000.00	2,510,000.00	-160,000.00	106.81%
210702	Дотоод албан томилолт	2,350,000.00	2,510,000.00	-160,000.00	106.81%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,758,900.00	2,886,610.00	872,290.00	76.79%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	310,000.00	288,000.00	22,000.00	92.90%
210803	Даатгалын үйлчилгээ	383,000.00	238,500.00	144,500.00	62.27%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	244,800.00	166,034.00	78,766.00	67.82%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	800,000.00	33,000.00	767,000.00	4.13%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,643,600.00	1,802,000.00	-158,400.00	109.64%
210807	Газрын төлбөр	377,500.00	359,076.00	18,424.00	95.12%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,694,700.00	5,090,940.00	-1,396,240.00	137.79%

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,694,700.00	5,090,940.00	-1,396,240.00	137.79%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,000,000.00	48,000,000.00	0.00	100.00%
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,000,000.00	48,000,000.00	0.00	100.00%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,000,000.00	48,000,000.00	0.00	100.00%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	1,100,380,506.98	-	1,100,380,506.98
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	50,462,311.49	-50,462,311.49	
132001	Орон нутгийн төсвөөс	0	50,462,311.49	-50,462,311.49	
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	1,038,525,800.00		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0	1,038,525,800.00		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	11,392,395.49		
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0	11,392,395.49		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэс сумын Эрүүл мэндийн төв нь иргэн бүр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй чирэгдэлгүй нээлттэй түргэн шуурхай үзүүлж хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Тайлант онд сумын хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй чанартай хүргэж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг тасралтгүй явуулснаар хүн амын өвчлөлийг бууруулж, дундаж наслалтыг уртасган, эрүүл аж төрөх дадал заншилд сургахад оршино гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30,181.5 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,239.6	94,929.2	87,689.5
Авлага	91,929.0	1,882.1	-90,046.9
Бараа материал	75,180.3	93,594.2	18,413.8
Үндсэн хөрөнгө	1,733,354.3	1,687,115.2	-46,239.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,907,703.4</b>	<b>1,877,520.9</b>	<b>-30,182.5</b>
Өр төлбөр	0	6,299.3	6,299.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,907,703.4	1,871,221.5	-36,481.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,907,703.4</b>	<b>1,877,520.9</b>	<b>-30,182.5</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 87,689.5 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 90,046.9 мянган төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний авлага 2022 онд хүлээн авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 93,594.2 мянган төгрөг болж 18,413.8 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан эм боох материал, хүнсний материал, аж ахуйн материал зарцуулагдаагүй үлдсэн мөн 39,283.3 мянган төгрөгийн эм боох материал хандиваар авсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,687,115.2 мянган төгрөг болж 46,239.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант хугацаанд 21,782.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 19,755.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч 91,671.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр 6,299.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагад өгөх өглөг болон ХХОАТ өглөгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,871,221.5 мянган төгрөг болж 36,481.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 53,300.2 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө худалдан авсан, бараа материал хандиваар авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 246,569.3 мянган төгрөгөөр буюу 28 хувиар өссөн байна. Энэ нь цалин хөлс болон урамшуулал, хангамж бараа материал, нормативт зардлуудын өсөлт нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 998,814.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийг 998,814.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,049,364.3 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 50,550.2 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 998,814.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 50,550.2 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,038,525.8 мянга, нийт 1,089,076.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,009,659.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй

## Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнд ногдох нормативаар	458,923.8	399,873.7	59,050.1	87.1%
2	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	467,910.0	454,792.5	13,117.5	97.1%

Нэг иргэнд ногдох нормативаар хөтөлбөр арга хэмжээний 59,050.1 мянган төгрөгийн хэлбэлзэл үндсэн болон нэмэгдэл цалин хөлстэй холбоотой үүссэн байна.

Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ хөтөлбөр арга хэмжээний 13,117.5 мянган төгрөгийн хэлбэлзэл нь урамшуулал, тээвэр шатахуун, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл, багаж техник хэрэгсэл, урсгал зардал зэргийн хэмнэлттэй холбоотой үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ариун төгс оршихуй Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Баялаг, аудитор С.Эрдэнэчимэг, Ч.Сэлэнгэ, В.Сэлэнгэ нар гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлэн ажиллаа.

Тэс сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ариун төгс оршихуй аудит ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дугаар 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан үр дүнгийн тайлангийн нийт зардал 630,035.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 6,300.3 мянган

төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан. Гүйцэтгэлийн шатанд энэхүү нөхцөл байдал оршин байхгүй болсон учир дахин шинэчлэн тогтоосон болно. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,124,318.6 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 11,243.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,994.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**  
АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа оруулсан 97, хугацаа хоцроож мэдээлсэн 12, байршуулаагүй 10 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус эмнэлэг нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Тайлант хугацаанд 212,317.9 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 58,597.6 мянган төгрөгийн худалдан авалт нь и баримтаар баталгаажгаагүй байна.



## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М. БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М. БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"  
ХХК-ийн АУДИТОР /В. СЭЛЭНГЭ/

2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр

